

Монголбанк-нд тайлагнах нь

2021 он 4 сарын 26

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Уламбаярын жилийн тайлан

Миний бие Баянсангийн Уламбаяр нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр гэрээний дагуу үргэлжлүүлэн ажиллалаа. Өнгөрсөн 2020 оны 4 сард тайлагнаснаас хойш нэг жилийн хугацаанд ТУЗ-ийн гишүүний албан үүргийн хүрээнд доорх ажлуудад оролцсон байна.

- ТУЗ-ийн байнгын хуралд нийт 4 улиралд буюу 2020 оны 6 сарын 24, 9 сарын 16, 12 сарын 9, 2021 оны 3 сарын 30-ны хурлуудад оролцсон.
ТУЗ-ийн хурлын хүрээнд, ТУЗ-ийн Эрсдэлийн хорооны хурлууд, Аудитын хорооны хурлуудад үндсэн гишүүнээр, Засаглалын хорооны хурлуудад ажиглагчийн статустайгаар 2020 оны 6 сарын 23, 9 сарын 15, 12 сарын 8, 2021 оны 3 сарын 29, 3 сарын 30-ны -нд тус тус оролцжээ.
- Дээрх улирал дутмын ТУЗ-ийн хурлаас гадна, ТУЗ болон менежментийн багийн гишүүд хооронд зохион байгуулагддаг, ажлын явцтай танилцах, цаг үеийн стратегийн чухал шийдвэр гаргах зорилготой хурал, уулзалтуудад тогтмол идэвхитэй оролцсон.
Эдгээр нь 2020/05/20, 2020/07/23, 2020/08/20, 2020/10/21, 2021/01/26, 2021/02/25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан байна.
Мөн 2021/02/15-нд Банкны хувьцааг олон нийтэд нээлттэй арилжиж (IPO) эхлэхтэй холбогдуулан стратеги болон ерөнхий төлөвлөгөөний талаар, 2021/03/10-нд Банкны 2020 оны санхүүгийн аудитын тайлангийн талаар хуралд оролцсон.
- 2020/11/24-нд Банкны дунд болон урт хугацааны стратегийг тодорхойлох ТУЗ-ийн хуралд оролцож, өөрийн санал шүүмжлэлийг холбогдох төлөвлөгөөнд тусгуулсан.
- Хувь нийлүүлэгчдийн хуралд 1 удаа буюу 2021 оны 3 сард.
- 2021/2/04-нд Банкны бүх ажилчид оролцдог, оны тайлан ололт амжилтаа хуваалцдаг “Townhall meeting” хуралд оролцсон.
- Цахим болон эчнээ хэлбэрээр холбогдох мэдээлэлтэй танилцах болон шийдвэр гаргах.
- Банкны ажиллагаатай танилцах болон хяналт тавих үүднээс, шаардлагаас хамааран зохих удирдлагын багийн ажилтнуудтайх уулзалтууд.

Банкны 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг дүгнэх, удирдлагын багын ажлыг дүгнэх, 2021 оны төсөв, хөрөнгө оруулалт, хүний нөөц, стратегийг батлах зэрэг асуудлуудад идэвхитэйгээр хэлэлцэж, саналаа өгч оролцсон.

Үүнд, тухайлбал Гүйцэтгэх захирлын өнгөрсөн оны ажлын үр дүнг дүгнэх, ирэх оны төлөвлөгөөтэй холбогдуулан КPI-г нь тодорхойлж батлах, мөн хөлсөөр ажиллах гэрээг сунгах зэрэг асуудал, удирдлагын түвшний шийдвэрүүд багтсан болно.

Банкны бүтэц зохион байгуулалтыг хэлэлцэх батлах, засаглал, эрсдэлийн удирдлага, цалин урамшуулал, хүний нөөцтэй холбогдох төрөл бүрийн дотоод журам, бодлогын



бичиг баримтуудыг хэлэлцэх, батлах шийдвэрүүдэд мөн идэвхитэйгээр оролцож, саналаа тусгуулсан.

Санхүүгийн тайлагнал болон Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн хорооны хурлын хэлэлцүүлэг, шийдвэрээр дамжуулан, Банкны эрсдэлийн удирдлагын зохистой болон найдвартай байдлыг хангах талаар ажиллаж ирсэн. Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан захирал болон Эрсдэлийн хариуцсан захирал нар нь харилцан холбоотойгоор энэ үүргийг хэрэгжүүлж байна.

2020 оны эцсийн санхүүгийн тайлан нь олон улсын Делойт фирмээр аудитлагдсан бөгөөд үнэн зөв, зохих хууль журмын дагуу тайлагнагдсан нь тухайн аудитын дүгнэлтээр баталгаажсан. Мөн Делойт фирмийн гүйцэтгэсэн 2020 оны эхний хагас жилийн review-г хэлэлцэж баталсан болно.

Монголбанкны журамд заагдсан болон Банкны эрсдэлийн зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангах талаар сайтар хянаж чиглүүлж ажиллаж байна.

2020 онд шинээр тулгарсан эрсдэл болох Ковид цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор, Банкны үйл ажиллагаа, ажилчид болон харилцагчдыг шинэ эрсдэлээс хамгаалах талаар идэвхитэй хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авах талаар удирдлага чиглэлээр ханган ирсэн.

Хараат болон холбоотой компаниудын удирдлага

Миний бие нь ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажилладаг боловч толгой компани Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ба хамааралтай компаниуд болох Хас Лизинг, Хас Сэкьюритиз, Тэнгэл Капитал, Тэнгэр Даатгал зэрэгт ТУЗ-ийн гишүүн биш тул энэ талаар албан ёсоор мэдээлэл авах, шийдвэр гаргах зүйл байдаггүй. Тиймээс энд мэдэгдэж тайлагнах тодорхой зүйл байхгүй болно.

Ашиг сонирхолын зөрчилтэй хэлцэл

Банкны үйл ажиллагаанд, ашиг сонирхолын зөрчилтэй этгээдэд зүй бусаар зээл олгох болон нөлөөлөх ноцтой үйлдэл ТУЗ-ийн ажлын хүрээнд ажиглагдаагүй.

Ашиг сонирхолын зөрчил үүсэхүйц цөөн тооны томоохон хэлцлийн хувьд, Банкны дотоод журмын дагуу хараат бус гишүүдийн саналыг авсны үндсэн дээр шийдвэр гарж байгаа. Хараат бус гишүүний хувьд уг асуудлууд дээр онцгойлон анхаарч, хяналт тавьж, шийдвэрүүдэд оролцсон.

Үүнд, 2020 оны 10 сард Банкны зүгээс хамааралтай компани болох Хас Лизинг-д өмнө олгогдсон байсан 15.5 тэрбум төгрөгийн зээлийн шугамыг 12 сараар сунгах болон зээлийн хүүг 14.4% болгож нөхцлийг өөрчлөх хүсэлт Банкны зээлийн хорооноос ТУЗ-ийн Эрсдэлийн хороонд хүргэгдэж ирсэн бөгөөд ТУЗ-ийн тус хорооны гишүүн болон хараат бус гишүүний хувьд уг хүсэлт нь Банкны зохих дотоод дүрэм журмыг хангасан гэж судалж үзэн, шийдвэрт санал өгсөн болно.

Банкны засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа

Банкны засаглал хэвийн сайн хэрэгжиж байна. Хувь нийлүүлэгч, ТУЗ ба удирдлагын багийн хоорондох мэдээлэх процес, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол



улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу ажиллаж байна.

Мөн ТУЗ нь Монголбанкны журам болон ХасБанкны засаглалтай холбогдох дотоод журмын дагуу, ТУЗ-ийн гишүүдийн өөрсдийгөө дүгнэх санал асуулгыг тогтмол явуулдаг бөгөөд үүнд идэвхитэйгээр оролцсон болно.

ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны ба түүний харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, аливаа холбогдох хууль журмыг зөрчсөн ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.

ТУЗ дээр, миний бие хууль журмын дагуу Эрсдэлийн хороо болон Аудитын хороонд хараат бус гишүүний хувиар албан ёсоор харьяалагдаж, үргэлжүүлэн ажиллаж байна.

Аудит ба дотоод хяналт

Улирал тутмын ТУЗ-ийн хурлын хоорондох хугацаанд, Банкны дотоод аудитортой зарим тулгамдсан асуудлуудын хувьд зөвлөлдөх, хяналт тавих, удирдлагаар хангах ажлыг биечилж хийж байсан. Үүнд дотоод хяналттай асуудлуудаас гадна, хөндлөнгийн аудитын фирмтэй холбоотой ажлууд мөн хамаарна.

Бусад

Банкны тухай хууль Монгол улсад шинэчлэгдэн батлагдаж буйтай холбоотойгоор, тус хуулийн холбогдох шинэ заалтуудад нийцэж ажиллах шаардлага банкуудад шинээр тулгарч байна. Тус нөхцөл байдалтай холбогдуулан, Банкны ТУЗ дээр IPO буюу олон нийтэд хувьцаагаа санал болгон худалдаалж, хувьцаа эзэмшигчийн бүтцийг илүү нээлттэй бөгөөд бага бөөгнөрөлтэй болгох талаар судалж, тодорхой саналуудыг хэлэлцэж байгаа бөгөөд тус асуудалд идэвхитэй оролцож, шийдвэр болон дараагийн бодитой алхамуудад өөрийн саналаа тусгуулсан болно.

Хүндэтгэсэн,

Б. Уламбаяр

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн